

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ
ТОГТМОЛ ХЭВЛЭЛД ТУСГАЖ БУЙ БАЙДАЛ

(Өдөр тутмын сонины жишээн дээр)

Ариун*

* ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн багш, доктор, дэд профессор

Түлхүүр үг: хүнлэг ёс, хүмүүнлэг нийгэм, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэнцвэртэй, үнэн зөв мэдээлэл, үг сонголт

Оршил

Монгол Улс НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” болон түүний нэмэлт протоколд 2008 онд нэгдэн орсноор уг конвенциор баталгаажсан бүх эрх, эрх чөлөөг дүүрэн хангах эрмэлзлээ дэлхийн олон нийтэд нотлон харуулсны зэрэгцээ иргэдийнхээ өмнө энэхүү зайлшгүй чухал олон улсын гэрээг хэрэгжүүлэх амаргүй үүргийг хүлээсэн билээ.

Хүнлэг ёс, хүмүүнлэг нийгмийн зарчмаар бол ХБИ-ийг нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах нь үр дүнд хүрэх гол арга аж. Гэвч эдгээр хүмүүсийг тээршаасан, бусдаас өөр хүн гэж үзэх хандлага нийгэмд түгээмэл байна. Ийм хандлага нь ХБИ-ийн эрхийг бүдүүлгээр зөрчих үндэс болж, тэдний хүнлэг ёсны хайр халамж хүртэх эрхийг боогдуулсаар байна. Иймд тэднийг бусад хүмүүстэй эрх тэгш байлгах, тэдний талаар нийгэмд

зөв ойлголт төрүүлэхэд сэтгүүл зүйн салбар онцгой үүрэгтэй.


Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн гуравдугаар шат буюу 2015-2019 онд зорилтот бүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэргэжилтнүүд, сэтгүүлчид хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, ойлголт хандлагыг өөрчлөхөд хэвлэл мэдээлэл онцгой үүрэгтэй гэж үзсэн хэрэг. Италийн төрийн бус АИФО байгууллагаас явуулсан судалгааны дүнгээс харахад манай улсад нийт хүн амын 4.8 хувь буюу 115 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд тэдний 65 хувь нь эмэгтэйчүүд бол 34000 хүүхэд байдаг гэжээ. Эдгээр хүмүүсийг бэрхшээлээр нь гадуурхах, тусгаарлах, эрхийг нь зөрчих, доромжлох явдал манай нийгэмд цөөнгүй. Тогтмол хэвлэл нь нэг талаас иргэдийн дуу хоолой болдог ч нөгөө талаас олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлдэг хүчтэй хэрэгслийн хувьд ХБИ-ийн талаарх аливаа асуудлаар хэр зэрэг бодитой, тэнцвэртэй, үнэн зөв мэдээлж байгааг олж илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Дэлхийн аль ч улсад, өндөр хөгжилтэй, хөгжиж буй аль ч нийгэмд эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдсөөр ирсэн бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд юм. Тэдэнд хийж бүтээх, сурч боловсрох, "хүний дайтай амьдрах" эрмэлзэл дүүрэн боловч хүнээс гадуурхах нийгмийн орчин, чадвар, чадавхийг нь үл тоомсорлох хандлагын улмаас хүсэл мөрөөдлөө биелүүлэх боломж хомс байна. Иймд ХБИ-эд тэгш боломж олгох, тэдний "хүн" хэмээх эрхэм чанар, тэд нийгмийн халамж хүртэгч идэвхгүй хэсэг биш, баялаг бүтээгч нийгмийн нэгээхэн хэсэг мөн гэдгийг баталж, тэдний эрх, эрх чөлөөг бүрэн хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн оролцоо ямар байгааг судалж хэвлэл мэдээллийн тусгаж буй өнөөгийн байдал, тэдний ойлголт хандлагад дүгнэлт хийхийг зорилоо.

Энэ судалгааны ажлын хүрээнд Монголын хамгийн олон уншигч,

захиалагчтай “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан” сониныг сонгон авсан бөгөөд 2013, 2014, 2015 оны 1-12-р сар буюу бүтэн 3 жилийн нийт 936 дугаарыг шүүн судалсан юм. Дээрх хэвлэлд 3 жилийн хугацаанд ХБИ-ийн тухай нийт 104 нийтлэл, материал гарсан байна.

Судалгаа хийх явцад энэ сэдвийг манай тогтмол хэвлэлүүд маш бага тусгадаг нь ажиглагдлаа. Нэг сонинд жилд дунджаар 8-9 материал гарч байна гэдэг нь чамлалттай юм. Сонин тус бүрийн хувьд аль нэг сонин нь нөгөөгөөсөө энэ сэдвийг илүү их тусгаж, анхаарч бичдэг гэсэн дүгнэлт хараахан хийж болохооргүй байсан. Дотор нь харьцуулахад “Үндэсний шуудан” сонин бусад сониноосоо илүү даацтай, асуудалд бодитой ханддаг нь судалгааны явцад анзаарагдлаа.



Дээрх сонинуудад ХБИ-ийн талаар ямар нэг байдлаар тусгасан 104


материалыг бичлэгийн төрөл зүйлийн хувьд авч үзвэл:



ХБИ-эд тулгамдсан аливаа асуудлаар тогтмол хэвлэлийн тусгац сул бөгөөд даацтай хандаж чаддаггүйг харуулж байна.

Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн хүрээнд ХБИ-эд мэдээлэл түгээх асуудлыг тусгасан ч бодит байдалд тэдэнд зориулсан мэдээлэл, мэдээлэл түгээх хэрэгсэл хангалтгүй байна. Мэдээлэл түгээх хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилтийг ХБИ ажиллаж болохуйц

компьютер болон бусад хэрэгсэл байдаггүй гэж хариулсан бол телевизээр дохионы орчуулга ашиглаж мэдээлэл дамжуулах, товгор үсэг бүхий ном, хэвлэл байдаг ч олдоц, хүрэлцээ муу байдаг гэснийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн шинжилгээ, үр дүнг тодорхойлох судалгааны тайланд ч тэмдэглэсэн байдаг.



Судалгаа хийсэн нийтлэлүүдэд дараах агуулга, өнцөг ажиглагдаж байна. Үүнд:

✓ ХБИ-эд орчин байхгүй, тэдэнд тусламж хэрэгтэй

✓ ХБИ-ийн тоо өссөөр байна

✓ ХБИ-ийг төр анхааралдаа авах хэрэгтэй байна

✓ ХБИ-эд тусалж байна, ХБИ-дэд зориулсан үйлчилгээ бий болсон тухай

✓ ХБИ-ийн хөдөлмөр ажил эрхлэлтийн тухай, тэднийг нийгэмд зөвөөр таниулах өнга аястай.

Манай ХМХ-үүд ХБИ-ийн тухай бичиж буй байдлыг аваад үзвэл маш явцуу хүрээнд, мөн тэднийг өрөвдүүдсэн, ялгаварласан, бусдаас өөр гэж харуулсан байдлаар бичиж байна. Дээрх ангилсан таван өнцөг хандлагыг аваад үзвэл эхний дөрөв нь ХБИ бусдаас өөр, тэдэнд нийгмийн халамж тусламж хэрэгтэй, өрөвдмөөр хүмүүс гэсэн ойлголт өгөхөөр байна. Гэгээлэгдүү зөвөөр ойлгуулах өнцгөөс бичсэн мэдээлэл нь голдуу ХБИ-ийн өөрсдийн зохион байгуулсан үйл ажиллагаа, өөрсдийгөө ойлгуулах гэж оролдсон хандлага байгааг анхаарах хэрэгтэй. Ийм төрлийн мэдээллийн дийлэнх нь ХБХ-ийн уран зураг, гар урлал гэх мэт зүйлийн сургалт, үзэсгэлэнгээс хийсэн сурвалжлага байна. Тухайлбал:

ХБИ-д орчин байхгүй, тэдэнд тусламж хэрэгтэй гэсэн агуулгатай мэдээлэлд ямар асуудлууд тусгаж байгааг харвал

✓ ХБ-тэй хүүхдийн суралцах орчин шаардлага хангахгүй байна

✓ Дохионы хэлмэрч хүрэлцээгүй байна

✓ ХБИ-эд зориулсан барилга байгууламж нь өөрөө бэрхшээлтэй байна

✓ ХБИ-эд зориулсан налуу шат, зам, цахилгаар өлгүүр зэрэг байхгүй байна

✓ ХБИ-эд зориулсан ном сурах бичиг хэрэгтэй байна гэсэн асуудлуудыг тусгасан

ХБИ-ийн тоо баримт, мөн тоо өссөөр байна

✓ Монгол улсад 2015 оны байдлаар 11365 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг тухай судалгаа бий

✓ Сургуулийн насны хүүхдийн 10 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, мөн тэдний 10 хувь л сургуульд хамрагддаг чаддаг

✓ 2014 оны судалгаагаар 99,573 ХБИ байна. Тэдний 35,6 хувь төрөлхийн, 64,1 хувь нь олдмол, 18,5 хувь нь зам тээврийн ослоос үүдэлтэй

✓ ХБИ тоо өссөөр байна. Энэ нь төрөхийн шарлалт, эмч, эмнэлгийн буруу, нийгмийн байдалтай холбоотой

ХБИ-ийг төр анхааралдаа авах хэрэгтэй байна

✓ ХБИ-эд мэргэжлээрээ ажиллах боломж байна

✓ ХБ-тэй хүүхдүүдийн сурах эрх зөрчигдөж байна

✓ ХБИ-эд төр анхаарал хандуулахгүй байна

✓ ХБ-тэй хүүхдүүдийн цэцэрлэг, сургууль хүрэлцэхгүй байна

ХБИ-эд тусалж байна, ХБИ-эд зориулсан үйлчилгээ бий болсон тухай

- ✓ ХБХ-эд зориулсан спортын ордон, номын сан, цэцэрлэг, 317 ажлын байр бий болно
- ✓ ХБХ-ийг боловсролд эрт хамруулж эхэлнэ
- ✓ ХБХ улс төрд оролцох боломжтой
- ✓ ХБХ-ийн асрамжийн газарт хүнсний ногоогоор тусламж үзүүлжээ
- ✓ ХБ-тэй хүүхдээ рашаан сувилалд хөнгөлөлттэй үнээр авч явах боломжтой
- ✓ ХБХ-эд сэргээн засах эмчилгээ хийж байна
- ✓ ХБИ-эд тэргэнцэр авахад туслах зорилгоор хандивын тоглолт хийнэ
- ✓ Хараагүйчүүдийн үндэсний холбоонд 50 сая төгрөгийн тусламж үзүүлжээ гэх мэтээр харуулжээ.

Харин ХБИ-ийн хөдөлмөр ажил эрхлэлтийн тухай, тэднийг нийгэмд зөвөөр таниулах өнгө аястай

- ✓ ХБИ-ийг ажиллах хүч гэж харахгүй байна
- ✓ Төрөлхийн сонсголгүй хүүхдүүд ердийн сургуульд сурах боломжтой
- ✓ Хүний эрхийг хамгаалахыг уриалсан өдөрлөг боллоо
- ✓ ХБИ-ийг ажилд зуучилах өдөрлөг боллоо
- ✓ ХБИ-ийг нийгмийн хөгжлөөс хоцрохгүйгээр бие даан амьдрах талаар сургалт зохион байгууллаа
- ✓ ХБИ-ийн гар урлалын бүтээлээр үзэсгэлэн зохион байгууллаа
- ✓ Тэргэнцэрийн зөв хэрэглээг хэвшүүлэх сургалт зохион байгууллаа
- ✓ ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, "Бид бүгдийг чадна" гар урлалын бүтээлийн үзэсгэлэнгийн сурвалжлага

зэргийг нэрлэж болно. ХБИ-ийн тухай нийгэмд үнэн зөв, бодитойгоор, үл ялгарварлан тусгах нь зүйтэй юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхээр л нийгмээс тусламж, халамж хүсч суудаг хүмүүс биш, тэд ч гэсэн бусадтай адил тэмцэж, ялж, амжилт байгуулж чаддаг гэх агуулгыг гаргаж хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүсийг идэвхжүүлэх, нийгмээс өөрсдийгөө тусгаарлах хандлагыг өөрчлөх зорилготойгоор бичих ёстой. Иймэрхүү өнгө аяс харуулсан цөөн хэдэн нийтлэл нь жилийн бүрийн 11-р сарын 1-нд дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг "Өгөх өдөр" хэмээн аяны хүрээнд ХБИ өөрсдөө зохион байгуулсан үзэсгэлэн, хурал, жагсаал зэрэг үйл ажилагаанаас хийсэн сурвалжлага байгаа юм. Өөрөөр хэлбэл ХБИ өөрсдийгөө олон нийтэд ийн ойлгуулах хүсэл эрмэлзэлтэй байгааг манай сэтгүүлчид тэр бүр анзаарч мэдрэхгүй байна гэж үзэж байна.

Судалгаа хийсэн ХМХ-ээр "Өгөх өдөр"-ийн хүрээнд зохион байгуулсан үзэсгэлэнгийн үеэр хийсэн ажлыг ярилцлага, сурвалжлагуудын гарчгаас харж болно.

– "Энэ миний амьдрал, эрүүл хүн шиг аж төрөхийг хүснэ" ("Үндэсний шуудан". 2013.08.31. №198)

– "Бид өрөвдүүлж биш, атаархуулж амьдарна гэж боддог" ("Үндэсний шуудан". 2013.09.11. №207)

– "Тэд идэвхтэй амьдрахыг хүсч байна" ("Өнөөдөр" сонин. 2013.04.03. №078)

– "Бидний сэтгэлийн бэрхшээл тэднийг хөгжлийн бэрхшээлтэй болгож

байна” (“Өдрийн сонин”. 2015.10.30. №264) гэх мэт.

Сонины нийтлэлүүдийн гарчгийг аваад үзвэл дийлэнх нь мөн л тэднийг бусдаас өөр гэдгийг харуулсан, өрөвдүүлсэн, ялгаварласан өнгө аястай байгааг харж болно.

– “Тархины саажилттай хүүхдүүд үзэсгэлэнгээ дэлгэв” (“Зууны мэдээ”. 2015.11.02. №219)

– “Харааны бэрхшээлтэй иргэд брайль үсэг бүхий хавтасны тусламжтайгаар саналаа өгнө” (“Зууны мэдээ”. 2013.06.20. №155)

– “Тэргэнцэртэй болоход тусална” (“Үндэсний шуудан”. 2015.02.21. №013)

– “ХБИ-д дэмжлэг үзүүлэлээ” (“Өдрийн сонин”. 2013.11.08. №270)

– “Тэргэнцэр засварын төв нээгдлээ” (“Өдрийн сонин”. 2013.04.23. №105)

– “Энэ жил тархины саажилттай хүүхдүүдэд тусална” (“Өдрийн сонин”. 2014.10.30. №264)

– “Хараагүй хүнийг дайрчихаад 2500 төгрөг өгөөд зугтжээ” (“Өдрийн сонин”. 2014.12.01. №239)

– “Хөөрхий хүүхдүүдэд хөгжил хэрэгтэй байна” (“Зууны мэдээ”. 2014.11.10. №222)

– “Дауны өвчтэй хүүхдүүдэд тусална” (“Үндэсний шуудан”. 2013.10.22. №242)

– “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүчирхийлжээ” (“Өдрийн сонин”. 2014.03.21. №219) зэрэг гарчигтай нийтлэл дийлэнх нь байна.

“Өгөх нь авахаасаа илүү ерөөлтэй еэ” (“Өнөөдөр” сонин. 2015.11.02. №221), “Бидний сэтгэлийн бэрхшээл тэднийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байна” (“Өдрийн сонин”. 2015.10.30.

№264), “Бид өрөвдүүлж биш атаархуулж амьдарна гэж боддог” (“Үндэсний шуудан”. 2013.09.11. №207) гэх мэт гарчигтай цөөн хэдэн нийтлэл нийгэмд тэднийг зөвөөр таниулах, үнэн бодит байдлыг харуулахыг оролджээ.

Нийтлэлүүд дэх үг сонголтын хувьд:

– хэлгүй, дүлий,

– хэл ярианы бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй,

– сонсголгүй, хараагүйчүүд, хараагүй

– хараа сул,

– тэргэнцэртэй зэрэг олон үгийг сэтгүүлчид өөр өөрийнхөөрөө ашиглажээ.

Харин “Зөв харилцааны цагаан толгой” номд нийтэд нь:

– харааны бэрхшээлтэй

– сонсголын бэрхшээлтэй

– хэл ярианы бэрхшээлтэй хэмээн нэрдийдсэн нь зүйтэй хэмээсэн байна.

Судалгаа хийсэн нийт материалын гарчгийн 48 хувьд нь “хөгжлийн бэрхшээлтэй”, 24 хувь нь “тархины саажилттай”, “дауны өвчтэй”, “аутизмтай”, “хараагүй”, 28 хувь нь бусад үг хэллэг оруулсан нь тогтоогдлоо.

Мөн нийт гарчгийн 72 хувь нь үг хэллэгээр гадуурхсан өнгө аятай гэж үзэж болно. Энэ нь сэтгүүлчид ХБИ-ийн тухай хэрхэн яаж бичих ойлголтгүй, мөн бичиж буй сэдвээ, ярилцаж буй ярилцагчаа судалж мэдрээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

Хүний эрхийн үндэсний комисс, Европын холбоо, Италид төвтэй төрийн бус “Раул Фалерогийн анд нөхдийн холбоо” байгууллагын дэмжлэгтэйгээр “Зөв харилцааны

цагаан толгой” ном эрхлэн гаргажээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төрийг хүндэтгэн, бусдын адил эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай Монгол Улсын иргэн гэдгийг ухамсарлуулах зорилготой тухайн хүмүүсийн тусгай хэрэгцээ, харилцааны онцлогийг хамгийн энгийнээр тайлбарлан, нэр томъёог хэрхэн хэрэглэх талаар тодорхой заасан байдаг. Гэтэл судалгаанд хамрагдсан нийтлэл материалуудад ХБИ-ийн талаар тусгахдаа хэд хэдэн янзын нэр томъёо ашиглан бичжээ. Энэ нь нэг талаас хүний эрхтэй холбоотой асуудал төдийгүй, сонины хэл найруулгын хувьд үг буруу сонголт, гоо зүй зэрэг алдаа ажиглагдаж байна.

Сэдэв, агуулгын хувьд дээрх дөрвөн сонин нэгнээсээ ялгарах, шинэлэг байдал төдий л ажиглагдсангүй.

Жишээ нь, “Өнөөдөр” сонинд Ч.Мөнгөндалайтай хийсэн “Ярьж, сонсож чадахгүй ч Монгол орныхоо сайхныг харахыг хүсч байна” (2013.06.03), О.Саранчулуунтай хийсэн “Гүйгээрэй бүсгүй минь” (2013.11.04) ярилцлага гарчээ. Харин “Зууны мэдээ” сонинд Ч.Мөнгөндалайтай хийсэн “Амьдралын бэрхшээлийг давах нь миний зорилго” (2013.12.01), О.Саранчулуунтай хийсэн “Боломжгүй зүйл байдаггүйг харуулахыг хүссэн” (2013.11.28) бол “Үндэсний шуудан” сонины дугаарууд дээр мөн л Ч.Мөнгөндалай, О.Саранчулуун нарын тухай нийтлэл, ярилцлага гарчээ.



Жил бүрийн 11-р сарын 1-нд Үндэсний “Өгөх өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ өдрийн хүрээнд ХБИ-ийн бүтээлийн үзэсгэлэн болон бусад энз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. Тэдгээр үйл явдлаас хийсэн сурвалжлага, ярилцлага бусад

сар, өдөртэй харьцуулахад их гардгийг дээрх графикаас харж болно.

ДҮГНЭЛТ

➤ Сэтгүүлчид асуудлыг ул суурьтай дүгнэн бичдэггүй, таамаглан сургаар бичдэг, баримт нотолгоог

хангалттай ашигладаггүй, бүтээлч бус зэрэг олон асуудлаас болж ХБИ-ийн талаарх нийгмийн ойлголт сул байж болох юм.

➤ Өдөр тутмын сонинуудад ХБИ-ийн талаар харьцангуй бага тусгадаг бөгөөд цөөн хэдэн асуудлын хүрээнд л мэдээлдэг байна. Үүний нэг шалтгаан нь мэдээлэл бэлтгэхэд сонины удирдлага, эх сурвалж, тодорхой тоо баримт байдаггүй зэрэг нь сэтгүүлчдэд хүндрэл учруулдаг аж.

➤ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид тогтвортой үйл ажиллагааныхаа дүнд нийгмийн санаа бодлыг төлөвшүүлж, үнэн зөв мэдээллээр мэдлэг оюунд нь хөрөнгө оруулах, хүлээн авагчдын харах өнцгийг зөв чигт залах учиртай. Гэвч ХБИ-ийн талаар сэтгүүлч, хэвлэн нийтлэгчид өөрсдөө

буруу ойлголт, хандлагатай байгаа нь учир дутагдалтай юм.

Abstract

Journalist don't use crystal clear evidence, facts in their articles. They had have several mistake to transfer disability persona information in their articles. So that public never consider about disability person information. In the daily newspapers, journalists use their articles in uncreatable idea. They have just mentioned same angle as others. Because of that journalist don't have a right numeral fact, first and second handed sources. Also media and press organization would not give their permission to write about disability person information. Press or media organization must have to say the truth facts to their audiences. But it's still continue press and media gives wrong information about disability person their customers.